



СҮНЗИЙН ДАЙТАХУЙН УХААН

Эртний Хятадын гүн ухааны сэтгэлгээ, дайтахуйн эрдэм ухааны сонгодог судар “Сүнзийн дайтахуйн ухаан” монгол хэлээр анх удаа, бүрэн эхээрээ хэвлэгдэн 2005 онд гарлаа. Хятад судлагч, орчуулагч, сэтгүүлч М.Чимэдцэеэ өмнө нь Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл”-ийг хятад хэлнээс орчуулан уншигч түмэндээ хүргэж байсан бол энэ удаа эртний хятадын сонгодог утга зохиолын дээж цуврал болгон “Сүнзийн дайтахуйн ухаан”-ыг орчуулан толилуулж байна.

Энэхүү ном нь 13 бөлөгтэй, монгол, хятад хэлээр хэвлэгдсэн, эртний хятадын цэрэглэн дайтахуйн ухааны сонгодог бүтээл бөгөөд түүнийг орчуулан түгээж буй нь дайтахуйн сурталчилгаа ч биш, дайны түүх ч биш, хэдэн мянган жилийн тэртээх дайтахуйн онол эш, мэргэн ухаан, гүн сэтгэлгээ, яруу дүрслэлийг өнөөгийн уншигчдад толилуулж, тэрхүү мэргэн ухаан хэнд ч болов ухаарлын орчлонд авч хэрэглэх, үйл явдлыг цэгнэн дүгнэх, жишин бодох, оюун сэтгэлгээгээ тэлэхэд тустай хэрэг болох буюу.